

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Номт хан өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/67-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2024 он	Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	6-12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН НОМТ ХАН
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА П.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

2024.08.23 № СЭА-2024/СХ-НӨ-СТӨ-1113
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Номт Хан өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Номт Хан өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд шинээр иргэдэд үзүүлэхээр зөвшөөрөгдсөн 4 төрлийн тусламж үйлчилгээнээс сэргээн засах, өдрийн эмчилгээ, гэрийн тусламж зэрэг 3 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн 26,170.0 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

ӨЭМТ нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжиж “Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл” гэсэн хариуцлагын хэлбэртэйгээр хүн

амд эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж, үйлчилгээг үзүүлэх зорилготой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд санхүүгийн тайлан нь төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, тайлагнагдах зохицуулалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймаг дахь ЭМДХ нь ӨЭМТ-тэй байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ”-г ЭМДҮЗ-ийн 07 дугаар тогтоолд заасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр дүгнэж “Маш сайн” буюу 95.3 хувьтай үнэлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 сарын 22-ны өдрийн А/104 дугаар тушаалаар батлагдсан “Журам, гэрээний загвар шалгуур үзүүлэлт батлах тухай” журмын дагуу аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газрын дарга нь ӨЭМТ-ийн даргатай гэрээ байгуулж, санхүү болон үйл ажиллагаанд хяналт тавиагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	77,703,258.94	152,416,208.10
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	12,060,694.07	56,551,299.52
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	12,060,694.07	56,551,299.52
3121	Төгрөг	12,060,694.07	56,551,299.52
31211	Төрийн сангийн харилцах	12,060,694.07	56,551,299.52
33	АВЛАГА	-	15,855,502.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	15,855,502.00
35	БАРАА МАТЕРИАЛ	65,642,564.87	80,009,406.58
351	Түүхий эд материал	34,988,322.87	46,382,194.58
35110	Тусгай зориулалттай материал	31,354,062.87	23,865,413.07
35130	Эм боох материал	3,634,260.00	22,516,781.51
354	Хангамжийн материал	30,654,242.00	33,627,212.00
35410	Бичиг хэргийн материал	537,000.00	738,000.00
35420	Аж ахуйн материал	30,069,242.00	32,631,212.00
35430	Сэлбэг хэрэгсэл	48,000.00	48,000.00
35440	Түлш шатах тослох материал	-	210,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	208,087,439.05	192,132,118.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	208,087,439.05	192,132,118.13
392	Биет хөрөнгө	160,619,439.05	144,664,118.13
39201	Барилга, байгууламж	102,931,311.72	102,931,311.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(16,178,757.12)	(20,562,056.88)
39203	Авто тээврийн хэрэгсэл	28,698,350.00	23,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,898,350.00)	(14,900,000.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	121,772,128.61	122,996,149.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,254,345.27)	(75,687,725.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,117,817.48	10,084,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,993,250.87)	(3,197,760.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,748,448.10	4,748,448.10
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,323,913.60)	(4,748,448.10)
393	Биет бус хөрөнгө	47,468,000.00	47,468,000.00
39301	Программ хангамж	1,209,999.99	880,000.00
39302	Хасагдуулаг	(1,209,999.99)	(880,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,468,000.00	47,468,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	285,790,697.99	344,548,326.23
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	8,285,638.00	(0.00)
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,285,638.00	(0.00)
413	Өглөг	8,285,638.00	(0.00)
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	8,285,638.00	(0.00)

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	(0.00)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	277,505,059.99	344,548,326.23
51	Засгийн газрын хувь оролцоо	277,505,059.99	344,548,326.23
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	41,551,914.00	41,551,914.00
51101	Өмч: -Төрийн өмч	41,551,914.00	41,551,914.00
512	Хуримтлагдсан үр дүн	209,131,398.72	277,213,564.96
51210	Өмнөх үеийн үр дүн	209,131,398.72	210,170,298.72
51220	Тайланг үеийн үр дүн	-	67,043,266.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,821,747.27	25,782,847.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	285,790,697.99	344,548,326.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	942,399,202.73	730,399,841.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,794,106.16	9,797,224.96
120	Нийтлэг татварын бус орлого	39,794,106.16	9,797,224.96
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	39,794,106.16	9,797,224.96
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	24,957,663.29	5,288,125.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- БМ	14,836,442.87	4,509,099.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	902,605,096.57	720,602,616.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	641,884,211.57	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	583,982,011.57	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	57,902,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	248,440,885.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	248,440,885.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,440,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,440,000.00	-
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,840,000.00	720,602,616.33
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /урьдчилгаа 80 хувь/	-	678,577,114.33
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /гүйцэтгэл 20 хувь/	6,840,000.00	42,025,502.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	915,931,470.30	663,356,575.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	915,931,470.30	663,356,575.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	912,892,470.30	660,591,575.05
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	594,994,223.00	483,318,520.00
210101	Цалин	594,994,223.00	483,318,520.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,512,526.00	58,154,948.35

210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	39,241,431.00	45,187,873.35
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	7,128,137.00	8,243,208.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,020,597.00	1,089,192.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,122,361.00	3,634,675.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,665,518.00	14,294,471.88
210301	Гэрэл цахилгааны зардал	7,046,485.00	7,539,071.18
210302	Түлш, халаалтын зардал	5,113,093.00	5,412,961.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,505,940.00	1,342,439.70
2104	Хангамж, бараа материалын зардал	33,955,268.50	41,988,501.80
210401	Бичиг хэргийн материал	3,511,150.00	2,843,000.00
210402	Тээвэр, шатахууны зардал	3,478,610.00	3,832,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,095,700.00	1,117,000.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	60,000.00	225,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	22,741,808.50	7,144,642.00
210408	Бараа материал акталсны зардал	3,068,000.00	26,826,859.80
2105	Нормативд зардал	135,138,970.39	26,533,547.90
210501	Эм	135,138,970.39	24,886,547.90
210502	Хоол	-	1,647,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,510,000.00	3,645,000.00
210601	Багаж хэрэгсэл	7,650,000.00	-
210604	Урсгал засвар	12,860,000.00	3,645,000.00
2107	Томилолт, зочны зардал	662,600.00	1,821,400.00
210702	Дотоод томилолтын зардал	662,600.00	1,821,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,444,754.00	5,403,138.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,444,754.00	5,199,152.80
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	148,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	23,382.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	16,000.00
210807	Газрын төлбөр	-	16,104.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,008,610.41	25,432,046.32
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,008,610.41	25,432,046.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,039,000.00	2,765,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,039,000.00	2,765,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	3,039,000.00	2,765,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	26,467,732.43	67,043,266.24
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	26,467,732.43	67,043,266.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

SORT_ID	Үзүүлэлт	Төгрөг/	
		ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	902,605,096.57	704,747,114.33
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	902,605,096.57	704,747,114.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	641,884,211.57	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	583,982,011.57	-
131002	Засгын газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	57,902,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	248,440,885.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	248,440,885.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,440,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,440,000.00	-
1340	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,840,000.00	704,747,114.33
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /урьдчилгаа 80 хувь/	-	678,577,114.33
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих /гүйцэтгэл 20 хувь/	6,840,000.00	26,170,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	868,022,012.50	653,742,908.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	868,022,012.50	653,742,908.88
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,513,012.50	649,010,908.88
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	568,581,414.00	491,634,161.50
210101	Үндсэн цалин	560,461,414.00	481,564,161.50
210102	Нэмэгдэл	-	10,070,000.00
210104	Үр дүнгийн урамшуулал	8,120,000.00	-
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	68,639,697.00	58,154,944.85
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	68,639,697.00	35,615,520.97
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	9,707,650.39
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	3,783,071.53
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	822,609.90
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	8,226,092.06
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	13,805,518.00	14,294,471.88
210301	Гэрэл цахилгааны зардал	7,046,485.00	7,539,071.18
210302	Түлш, халаалтын зардал	5,113,093.00	5,412,961.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,645,940.00	1,342,439.70
2104	Хангамж, бараа материалын зардал	23,034,058.50	23,675,302.00
210401	Бичиг хэрэг	6,367,920.00	2,989,260.00
210402	Тээвэр, шатахуун	3,358,610.00	4,319,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,099,100.00	1,087,000.00
210404	Ном, хэвлэл	68,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	128,500.00	614,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,011,728.50	14,665,142.00
2105	Нормативт зардал	155,244,901.00	46,137,049.85

210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	148,266,851.00	38,998,049.85
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,978,050.00	7,139,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,823,050.00	8,322,700.00
210601	Багаж техник хэрэгсэл	1,617,000.00	-
210602	Тавилга	9,780,000.00	4,052,500.00
210604	Урсгал засвар	16,426,050.00	4,270,200.00
2107	Томилолт, зочны зардал	662,600.00	1,821,400.00
210702	Дотоод албан томилолт	662,600.00	1,821,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,721,774.00	4,970,878.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,699,774.00	4,766,892.80
210803	Даатгалын үйлчилгээ	-	148,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	23,382.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	16,000.00
210807	Газрын төлбөр	-	16,104.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,509,000.00	4,732,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,509,000.00	4,732,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	5,509,000.00	4,732,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,583,084.07	51,004,205.45
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	22,522,390.00	6,513,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,522,390.00	6,513,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,522,390.00	6,513,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,522,390.00	6,513,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,522,390.00)	(6,513,600.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	12,060,694.07	44,490,605.45
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,060,694.07
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,060,694.07	56,551,299.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41551914.00	26821747.27	209131398.72	277505059.99
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	41551914.00	26821747.27	209131398.72	277505059.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1038900.00	1038900.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41551914.00	26821747.27	210170298.72	278543959.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-1038900.00	-	-

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	67043266.24	67043266.24
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41551914.00	25782847.27	277213564.96	344548326.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,060,694.07	(12,060,694.07)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	692,767,600.00	660,256,508.88	32,511,091.12	95.3
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	692,767,600.00	660,256,508.88	32,511,091.12	95.3
210	Бараа, үйлчилгээний зардал	689,267,600.00	655,524,508.88	33,743,091.12	95.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	495,070,000.00	491,634,161.50	3,435,838.50	99.3
210101	Үндсэн цалин	485,000,000.00	481,564,161.50	3,435,838.50	99.3
210102	Нэмэгдэл	10,070,000.00	10,070,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,216,000.00	58,154,944.85	1,061,055.15	98.2
210201	Тэтгэврийн даатгал	35,616,000.00	35,615,520.97	479.03	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	9,800,000.00	9,707,650.39	92,349.61	99.1
210203	ҮОМШӨ ний даатгал	3,800,000.00	3,783,071.53	16,928.47	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	900,000.00	822,609.90	77,390.10	91.4
210205	Эрүүл мэндийн даатгал	9,100,000.00	8,226,092.06	873,907.94	90.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,600,000.00	14,294,471.88	1,305,528.12	91.6
210301	Гэрэл цахилгаан	7,600,000.00	7,539,071.18	60,928.82	99.2
210302	Түлш, халаалт	5,500,000.00	5,412,961.00	87,039.00	98.4
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	1,342,439.70	1,157,560.30	53.7
2104	Хангамж, бараа материалын зардал	26,150,100.00	23,675,302.00	2,474,798.00	90.5
210401	Бичиг хэрэг	4,500,000.00	2,989,260.00	1,510,740.00	66.4
210402	Тээвэр (шатахуун)	4,400,000.00	4,319,000.00	81,000.00	98.2
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,087,000.00	113,000.00	90.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,050,100.00	614,900.00	435,200.00	58.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	15,000,000.00	14,665,142.00	334,858.00	97.8
2105	Нормативт зардал	46,200,000.00	46,137,049.85	62,950.15	99.9
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	39,000,000.00	38,998,049.85	1,950.15	100.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	7,200,000.00	7,139,000.00	61,000.00	99.2

2106	Эд хогшил худалдан авах	37,172,000.00	14,836,300.00	22,335,700.00	39.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	2,650,000.00	12,350,000.00	17.7
210602	Тавилга	17,000,000.00	7,916,100.00	9,083,900.00	46.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	172,000.00	-	172,000.00	-
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,270,200.00	729,800.00	85.4
2107	Томилолт, зочны зардал	1,850,000.00	1,821,400.00	28,600.00	98.5
210702	Дотоод албан томилолт	1,850,000.00	1,821,400.00	28,600.00	98.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	8,009,500.00	4,970,878.80	3,038,621.20	62.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,800,000.00	4,766,892.80	3,033,107.20	61.1
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	148,500.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,000.00	23,382.00	1,618.00	93.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	16,000.00	16,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	20,000.00	16,104.00	3,896.00	80.5
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,500,000.00	4,732,000.00	(1,232,000.00)	135.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,500,000.00	4,732,000.00	(1,232,000.00)	135.2
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,500,000.00	4,732,000.00	(1,232,000.00)	135.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	692,767,600.00	704,747,114.33	(11,979,514.33)	101.7
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	692,767,600.00	704,747,114.33	(11,979,514.33)	101.7
134001	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	692,767,600.00	678,577,114.33	14,190,485.67	98.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	26,170,000.00	(26,170,000.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	12,060,694.07	(12,060,694.07)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	56,551,299.52	(56,551,299.52)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	18.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Номт Хан өрхийн эрүүл мэндийн төв /цаашид ӨЭМТ гэх/ нь “Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан анхан шатны тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн нэн шаардлагатай зарим тусламж, үйлчилгээг иргэнд тэгш хүртээмжтэй, тасралтгүй, чанартай, цогц байдлаар үзүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тусламж, үйлчилгээ авахаар ирсэн хүн бүрт үйлчлэх,
- Нотолгоонд тулгуурласан тусламж, үйлчилгээг үзүүлэх,
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгох,
- Иргэн бүрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй, чанартай, аюулгүй, чирэгдэлгүй, тасралтгүй үзүүлэх,
- Тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, оношлох, эмчлэх, сувилах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эрүүл мэндийг дэмжих, сэргээн засах, хөнгөвчлөх гэх мэт хүрээний дагуу үзүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 сарын 21 өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- 2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 6 дугаар тогтоолоор “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг шинэчлэн баталсан,
- 2023 оны 06 дугаар сарын 28-ны ЭМДҮЗ-ийн 7 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Номт Хан өрхийн эрүүл мэндийн төв нь ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний дагуу нэг иргэний нормативаар тооцож олгох санхүүжилт, тусламж үйлчилгээний санхүүжилт зэрэг гүйцэтгэлийн санхүүжилтээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж байна.

Гэвч төсвөөс олгож буй гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилтийн зарцуулалт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газраас хэрэгжилтийг дүгнэж, хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 344,548.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 58757.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,060.7	56,551.3	44,490.6
Авлага		15,855.5	15,855.5
Бараа материал	65,642.5	80,009.4	14,366.9
Үндсэн хөрөнгө	208,087.4	192,132.1	-15,955.3
Нийт хөрөнгө	285,790.6	344,548.3	58,757.7
Өр төлбөр	8,285.6		-8285.6
Засгийн газрын хувь /Эздийн өмч/	277,505.0	344,548.3	67,043.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө	285,709.6	344,548.3	58,757.7

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 56,551.3 мянган төгрөг болж 44,490.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үзүүлсэн тусламж үйлчилгээ, гүйцэтгэлийн санхүүжилт нэмэгдсэнээс шалтгаалсан байна.
- Авлага дансанд ЭМДС-аас авах санхүүжилтийн 15,855.5 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 80,009.4 мянган төгрөг болж 14,366.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хийгдэх урьдчилан сэргийлэх үзлэгийг дараа онд хийснээс шалтгаалан тест, урвалж бодис, эмнэлгийн хэрэгслийг зарцуулаагүйтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 192,132.1 мянган төгрөг болж 15,955.3 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн яамнаас 5,288.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авсан, өөрийн хөрөнгөөр 4,188.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан болон аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар тогтоолоор 24,314.6 төгрөгийн хөрөнгө акталж данснаас хасч, 25,432.0 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2023 оны төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1 хөтөлбөр 1 арга хэмжээгээр тооцон ЭМДС-аас нэг иргэний нормативт санхүүжилтээр 708,245.3 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, аймгийн ЭМГ-т хүргүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн ЭМГ-аас тус эрүүл мэндийн төвийн ЭМДС-аас төвлөрөх санхүүжилтийг **692,767.6** мянган төгрөгөөр хянаж баталгаажуулсан байна.

Гүйцэтгэлээр ЭМДС-ийн нэг иргэнээр тооцож олгох санхүүжилтээр 678,577.1 мянган төгрөг, эмчилгээ үйлчилгээний санхүүжилтээр 26,170.0 мянган төгрөг зэрэг 2 арга хэмжээний нийт **704,747.1** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний урсгал үйл ажиллагаанд **660,256.5** мянган төгрөгийг зарцуулж, 95.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр нормативаар тооцох зардал /80302/	692,767.6	649,830.9	-42,936.7	93.8
2	Тусламж үйлчилгээний орлого		10,425.6	10,425.6	100
	Дүн	692,767.6	660,256.5	-32,511.1	95.3

Эх сурвалж: ӨЭМТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шууд худалдан авах босго үнээс давсан 39,000.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр Азын нахиа, Архон, Монгол фарм, Доктор мэйк, эмийн сан, Архон фарм, Ультрафаз, Эм би жэй эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх төв зэрэг байгууллагуудтай шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулан бүртгэл тайланд тусгаж байх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, газар эзэмших эрхэнд байгуулсан элэгдлийг 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар залруулан бүртгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Номт хан өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 915,931.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,738.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн зөвлөмж хүргүүлэв.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.1 Илрүүлэлт: Шууд худалдан авах босго үнээс давсан нийт 39,000.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд

хязгаар бараа -20.0 сая төгрөг ажил 20.0 сая төгрөг" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээлбэл зохих 1 төрлийн 4 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 дахь “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг цахим системд хугацаанд бүрэн байршуулах.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар үе шатны ажлыг хэсэгчлэн хийх буюу түүвэрт хамруулан аудитыг гүйцэтгэсэн байна.

Аудитаар ямар нэгэн алдаа, зөрчил илрээгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **279,792.8** мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрч аудитын явцад 248,440.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, залруулаагүй 31,352.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулах зөвлөмж хүргүүлэв.

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны тохируулах бичилтийг устгаагүйгээс тайлант оны санхүүжилтийг 248,440.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Залруулаагүй алдаа:

2. Тус байгууллагын эзэмшлийн 31.352.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газарт 31,352.0 мянган төгрөгийн элэгдлийг байгуулан тайлант жилийн элэгдлийн зардалд тусгасан байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Байгуулсан элэгдлийн зардлыг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **41,955.9** мянган төгрөгийн зөрчил² илэрч 2,957.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 38,998.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх 2 зөрчилд зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Эмч, сувилагчдын баярыг тохиолдуулан эмч, ажилтнуудыг үндсэн цалингийн 20 хувиар буюу нийт 2,957.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэсэн заалт болон Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн *"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"* 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн үр ашигтай, арвилан хэмнэлттэй байх зарчмыг баримтлан, урамшууллыг давхардуулан олгохгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолын дагуу 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмч, ажилтнуудын цалинг шинэчлэн батлагдсан эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг үндэслэн шинэчлэн тогтоож, олгоогүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн *"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"* 241 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг шинэчлэн баталсан цалингийн сүлжээг үндэслэн тогтоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эмийн захиалгын хуудас, хэрэглэсэн эм тарианы зарлагын хуудас, хатгалт хийсэн тэмдэглэл зэрэг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр зөвхөн шаардах хуудсаар эм, эмнэлгийн хэрэгслийн 38,998.0 мянган төгрөгийн зарцуулалтын ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.7 дахь *"Анхан шатны баримтын*

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэл тайланд тусган ажиллах.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тус байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 31.352.0 мянган төгрөгийн үнэлгээ бүхий газарт 31,352.0 мянган төгрөгийн элэгдлийг байгуулан тайлант жилийн элэгдлийн зардалд тусгасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал”-ын 5.5 дахь “Газрын өмчлөх, эзэмших болон ашиглах эрхийг бүртгэлд тусгахдаа дараах бичилт хийнэ. Газар өмчлөх эрхийг үнэлсэн дүнгээр биет хөрөнгөөр, эзэмших /ашиглах эрхийг биет бус хөрөнгөөр бүртгэнэ. Газар эзэмших болон ашиглах эрхтэй бол биет бус хөрөнгөөр бүртгэх бөгөөд цаашид элэгдүүлэхгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Эзэмших эрхтэй газарт байгуулсан элэгдлийг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭПГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Санхүүжилтийг илүү тайлагнасан	1	248,440.8			1	248,440.8							
Эзэмших эрхтэй газарт элэгдэл байгуулсан	1	31,352.0			1	31,352.0			1	31,352.0	1	31,352.0	31,352.0
Дүн	2	279,792.8			2	279,792.8			1	248,440.8	1	31,352.0	31,352.0

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулал давхардуулан олгосон	1	2,957.9			1	2,957.9						
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан.	1	38,998.0					1	38,998.0				
Засгийн газрын 241 дүгээр тогтоолын дагуу цалинг шинэчлэн тогтоогоогүй	1				1							
Дүн	3	41,955.9			2	2,957.9	1	38,998.0				

Үүнээс

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	1						1	
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1						1	
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	39,000.0					1	39,000.0
Дүн	2	39,000.0					2	39,000.0